

БАТЛАВ
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
ДАРГА *М.М.М.М.М.* Д.МӨНХ-ЭРДЭНЭ



ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРҮҮДИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛД ДОТООД ХЯНАЛТ ХИЙХ АЖЛЫН УДИРДАМЖ

2021.09.27

Нэг. Зорилго

Байгаль орчин аялал жуулчлалын салбарт хэрэгжиж буй үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хүрээнд төлөвлөлт, бодлогын баримт бичгийн хэрэгжилт, албан хаагчдын ажлын зохион байгуулалт, ажлын гүйцэтгэлд дотоод хяналт хийх, зөвлөн туслах, илэрсэн зөрчлийг арилгахад чиглэнэ.

Хоёр. Үндэслэл, хамрах хүрээ

Эрх зүйн үндэслэл:

- Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралт “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”
- Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”
- Тогтвортой хөгжлийн боловсрол үндэсний хөтөлбөр
- Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах үндэсний хөтөлбөр
- Хог хаягдлыг бууруулах үндэсний хөтөлбөр
- Ус үндэсний хөтөлбөр

Дотоод хяналтын хамрах хүрээ: Дээрх бодлогын баримт бичиг, төлөвлөгөөний хэрэгжилт тэдгээртэй холбогдуулан гаргасан төлөвлөгөө тайлан, зохион байгуулсан арга хэмжээ, түүний хэрэгжилт, үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх.

Хамрагдах албан хаагчид: Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтнүүд

Гурав. Дотоод хяналт шалгалтын хугацаа

Хяналт, шалгалтыг 2021 оны 10 сарын 1-нээс 10 сарын 30-ны өдрийн хугацаанд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, хүний нөөц, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Гандулам, нягтлан бодогч Ц.Цэрэнчимэд хийж гүйцэтгэнэ.

№	Бодлогын баримт бичгийн нэр	Хугацаа	Хамрагдах албан хаагч
1	Хог хаягдлыг бууруулах үндэсний хөтөлбөр	9 сарын 30-наас 10 сарын 3	Н.Марал-Эрдэнэ
2	Хөрс хамгаалах, газрын доройтлыг бууруулах үндэсний хөтөлбөр	10 сарын 6-10	Т.Дашцэдэн
3	Ус үндэсний хөтөлбөр	10 сарын 13-17	Н.Намуунцэцэг
4	Тогтвортой хөгжлийн боловсрол үндэсний хөтөлбөр	10 сарын 20-24	Н.Солонго

Дөрөв. Хэрэгжүүлэх арга хэмжээ

1. Хяналт шалгалтыг албан хаагч бүрийн ажлын байранд, цаасан болон цахим баримтад тулгуурлан гүйцэтгэнэ.
2. Хяналтын явц, үр дүнг нотлох баримт, фото зургаар баталгаажуулна.
3. Хяналтын явцад илэрсэн зөрчлийг арилгуулах, зөвлөгөө, зөвлөмж өгөх, хугацаатай үүрэг даалгавар өгөх
4. Дотоод хяналт шалгалтын дүн, танилцуулгыг газрын даргад танилцуулж, мэдээллийг цахим хуудаст байршуулах

Тав. Дотоод хяналт, шалгалтын үр дүнг тайлагнах

Дотоод хяналт хийсэн тухай үнэлгээ, дүгнэлт, тайланг даргад 2021 оны 11 сарын 5-нд танилцуулна.

Дотоод хяналт, шалгалтын дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт тавина.